

Нэгдүгээр хэсэг: Сонгох даалгавар

Дараах даалгаврууд нь 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг нь зөв. Хамгийн зөв гэсэн нэг хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглэнэ. Нийт 46 сонгох даалгавар 80 оноотой. Амжилт хүсье.

1. Дараах хэмжигдхүүнүүдэд тохирох нэгжийг зөв харгалзуулна уу? (1 оноо)

- | | | |
|----------------|---------------------------|--------------|
| A. 1c 2d 3e 4b | 1. Абсолют температур | a. Вольт |
| B. 1d 2c 3e 4a | 2. Соронзон урсгал | b. стерадиан |
| C. 1c 2a 3e 4b | 3. Конденсаторын багтаамж | c. Кельвин |
| D. 1c 2e 3a 4b | 4. Биелэг өнцөг | d. вебер |
| E. 1d 2c 3a 4b | | e. Фарад |

2. Доорх нэгжүүдээс аль нь даралтын нэгж вэ? (1 оноо)

- A. N/m^2 B. J/C C. Vb/A D. Kl/c E. m/c^2

3. Доорх томъёонуудын аль нь хөдөлгөөний кинетик энергийг илэрхийлэх вэ? (1 оноо)

- A. $\omega = \frac{\Delta\phi}{\Delta t}$ B. $\phi = \omega_0 t + \frac{et^2}{2}$ C. $F = \gamma \frac{Mm}{R^2}$ D. $E_K = \frac{mv^2}{2}$ E. $S_1 v_1 = S_2 v_2$

4. Зөв харгалзуулна уу? (1 оноо)

- | | | |
|-------------------|-----------------|----------------------|
| A. 1d 2e 3c 4a 5d | 1. Үзэгдэл | a. Хөшүүргэн жигнүүр |
| B. 1b 2c 3e 4d 5e | 2. Загвар | b. Вольт |
| C. 1d 2c 3d 4e 5c | 3. Хэмжигдэхүүн | c. Гөлгөр хавтгай |
| D. 1e 2d 3a 4c 5b | 4. Нэгж | d. Уурших |
| E. 1d 2c 3e 4b 5a | 5. Хэмжих багаж | e. Соронзон урсгал |

5. Гэрэлтэй холбоотой дараах хэллэгүүдээс зөвийг нь сонгоно уу. (1 оноо)

- I. Тунгалаг биш биеэс сүүдэр үүсэх нь гэрэл шулуун тарахын баталгаа
II. Гэрэл ялгаатай тунгалаг орчинуудад ялгаатай хурдаар тарна
III. Гэрлийн даралт, фотоэффектийн үзэгдэл зэрэг нь гэрлийн долгиолог шинжтэй холбоотой

- A. Зөвхөн I B. Зөвхөн II C. Зөвхөн III D. I ба II E. I ба III

6. Жил бүрийн 12-р сарын 22-нд өдөр шөнө солигдохтой холбоотой ямар үзэгдэл болдог вэ? (1 оноо)

- A. Өдөр шөнө тэнцэх
B. Хамгийн урт шөнө, хамгийн богино өдөр
C. Хамгийн урт өдөр, хамгийн богино шөнө
D. Дэлхий тэнхлэгээ эсрэг зүгт эргэж эхэлдэг
E. Аль нь ч биш

7. Цахилгаан саармаг төлөвт орших титан Ti_{22}^{48} ба ванади V_{23}^{51} хоёрт нийт хэдэн электрон агуулагдах вэ? (1 оноо)

- A. 70 B. 74 C. 22 D. 45 E. 23


8. Биеийн давших хөдөлгөөний хурд 10 м/с бол нэгжийг зөв шилжүүлнэ үү. (1 оноо)

- A. 54 км/ц B. 72 км/ц C. 36 км/ц D. 108 км/ц E. 92 км/ц

9. $V = 3\text{л}$ эзэлхүүнтэй, $t_0 = 20^\circ C$ температуртай усыг $40^\circ C$ -ээр халаахад ямар дулаан шаардагдах вэ? $C_{yc} = 4200 \text{Ж}/\text{кг}^\circ C$ (1 оноо)

- A. 504 кЖ B. 756 Ж C. 756 кЖ D. 504 Ж E. 1008 МЖ

10. Зурагт өгөгдсөн хэмжээс бүхий $m = 500\text{г}$ масстай биеийн нягтыг тооцоолно уу? $a = 20\text{см}$, $b = 10\text{см}$, $c = 5\text{см}$ (1 оноо)




- A. $\rho = 0.25 \frac{\text{г}}{\text{см}^3}$ B. $\rho = 0.1 \frac{\text{г}}{\text{см}^3}$ C. $\rho = 0.2 \frac{\text{г}}{\text{см}^3}$ D. $\rho = 0.8 \frac{\text{г}}{\text{см}^3}$ E. $\rho = 0.5 \frac{\text{г}}{\text{см}^3}$

11. $\lambda = 400\text{нм}$ долгионы уртад харгалзах гэрлийн квантын энергийг олно уу. Планкийн тогтмол $\hbar=6.62 \cdot 10^{-34} \text{Ж}\cdot\text{с}$, вакуум дахь гэрлийн хурд $c=3 \cdot 10^8 \text{ м/с}$, нано утварыг $10^{-9} \text{ гэж тооцно. (1 оноо)}$

- A. $\approx 4 \cdot 10^{-19} \text{Ж}$ B. $\approx 5 \cdot 10^{-19} \text{Ж}$ C. $\approx 3.31 \cdot 10^{-19} \text{Ж}$
D. $\approx 2.84 \cdot 10^{-19} \text{Ж}$ E. $\approx 6 \cdot 10^{-19} \text{Ж}$

12. Гурван метал бие зурагт үзүүлсэн шиг шүргэлцэж байрлана. Сум дулаан шилжилтийн чиглэлийг зааж байгаа бол биеүдийн температурыг жишиг үү? (1 оноо)



- A. $T_1 > T_2 > T_3$ B. $T_2 > T_1 > T_3$ C. $T_3 > T_2 > T_1$ D. $T_3 > T_1 > T_2$ E. $T_1 > T_3 > T_2$

13. Соронзой холбоотой хэллэгүүдээс зөвийг нь сонгоно уу (2 оноо)

- I. Соронз нь хоёр туйлтай ба тэдгээрийг хооронд нь салгаж болдог
II. Соронзны ижил туйлууд таталцаж эсрэг туйлууд түлхэлцдэг
III. Атом нь бодисын соронзон бүтцийг илэрхийлэх эгэл соронз юм

- A. I ба III B. Зөвхөн II C. Зөвхөн III D. I ба II E. II ба III

14. Хавтгай толинд гэрлийн цацраг тусч ойно. Хэрэв туссан цацрагийн чиглэлийг хэвээр байлгаж толь 20° өнцгөөр эргэвэл толиноос ойсон цацраг ямар өнцгөөр эргэх вэ? (2 оноо)


- A. 20° B. 10° C. 30° D. 40° E. 50°

15. Газрын гадаргаас 40 м өндөрт орших 3 кг масстай биеийн газрын гадаргатай харьцангуй потенциал энэргийг олно уу. $g=10 \text{ м/с}^2$ (2 оноо)

- A. 1500Ж B. 1200Ж C. 500Ж D. 400Ж E. 600Ж

16. Зурагт өгөгдсөн тойргийн A цэг нь эгц босоо диагоналийн төгсгөл болно. A цэгээс өгөгдсөн 4-н ялгаатай хөвчийн дагуух ховилоор нэгэн зэрэг 4-н жижиг шаариг унагасан бол аль нь түрүүлж тойротг хүрэх вэ? (2 оноо)


- A. 4 B. 3 C. 2 D. 1 E. Бүгд зэрэг



17. Нэгэн савааны уртыг ялгаатай хоёр инерциал системд хэмжжээ. Саваа харьцангуй тайван байх системд хийсэн хэмжилтийн утга l_1 ба саваа уртынхаа дагуу харьцангуй өндөр хурдтай хөдөлж байх системд хийсэн хэмжилтийн утга l_2 бол энэ хоёр утгыг жишиг үү? (2 оноо)

- A. Бие хөдөлж байгаа тооллын системд биеийн шугаман хэмжээ хамгийн их тул $l_1 > l_2$
B. Бие тайван байгаа тооллын системд биеийн шугаман хэмжээ хамгийн их тул $l_1 < l_2$
C. Бие хөдөлж байгаа тооллын системд биеийн шугаман хэмжээ хамгийн их тул $l_1 < l_2$
D. Биеийн шугаман хэмжээ абсолют учраас $l_1 = l_2$ байна.
E. Бие тайван байгаа тооллын системд биеийн шугаман хэмжээ хамгийн их тул $l_1 > l_2$

18. Эгц дээш v хурдтай шидэгдсэн бие тодорхой хугацааны дараа буцаж ирнэ. x тэнхлэг эгц дээш чиглэсэн бол энэ тэнхлэг дээрх хөдөлгөөний хурдны проекц хугацааны хамаарлыг аль графикт зөв дүрсэлсэн бэ? (2 оноо)



19. $d = 4\text{мм}$ диаметртэй цилиндр хэлбэрийн хөнгөнцагаан дамжуулагчаар $I = 3.14 \text{ A}$ гүйдэл гүйж байгаа бол гүйдлийн нягтыг олно уу? (2 оноо)

- A. 0.25 A/mm^2 B. 1 A/mm^2 C. 0.125 A/mm^2 D. 0.5 A/mm^2 E. 1.25 A/mm^2

20. Гэрлийн цацраг n хугарлын илтгэгч бүхий биеийн гадарга дээр α -өнцөг үүсгэн тусч байна. Ойсон цацраг хугарсан цацрагтай 90° өнцөг үүсгэсэн бол n хугарлын илтгэгчийг α -өнцгөөр илэрхийлнэ үү. (2 оноо)


- A. $n = ctg\alpha$ B. $n = \sin\alpha$ C. $n = \cos\alpha$ D. $n = \tan\alpha$ E. $n = \sin\alpha/2$

21. Тус бүр нь 30 Ом-ийн 2 эсэргүүцлийг зэрэгцээ холбоод 15 В хүчдэлд холбосон бол хэлхээний ерөнхий гүйдлийн хүчийг олно уу? (2 оноо)

- A. 1.2 A B. 0.6 A C. 2.4 A D. 1 A E. 2 A

22. Босоо гөлгөр хананд m масстай нэгэн төрлийн жижиг бөмбөрцгийг утсаар бэхлэв. Бэхэлгээний утас босоо ханатай β өнцөг үүсгэнэ. Утасны татах хүч $T - g$ ол. (2 оноо)

$$A. T = \frac{mg}{\sin \beta} \quad B. T = \frac{mg}{\cos \beta} \quad C. T = mg \tan \beta \quad D. T = mg \sin \beta \quad E. T = mg \cos \beta$$




23. Th_{90}^{232} цацраг идэвхт задрал хийж Pb_{82}^{208} болон хувирав. Энэ хувирлын явцад хэдэн α , хэдэн β задрал явагдсан бэ? (2 оноо)

- A. $\alpha \sim 8, \beta \sim 6$ B. $\alpha \sim 6, \beta \sim 8$ C. $\alpha \sim 6, \beta \sim 4$ D. $\alpha \sim 4, \beta \sim 6$ E. $\alpha \sim 8, \beta \sim 4$

24. Зурагт С ба В биеийн координат хугацааны хамаарлын графикийг дүрслэв.

А: С ба В биеүдийн уулзалт хоорондын хугацааны завсар 12s
Б: С биеийн хурд 2.5 м/с байсан гэсэн С ба В биеийн хөдөлгөөний тухай $2 \text{ өгүүлбэрээс үнэнийг нь сонгоно уу?$ (2 оноо)

- A. Зөвхөн А B. Зөвхөн Б C. Хоёулаа үнэн D. Хоёулаа худал E. Зөв сонголт алга



25. Биеийг газрын гадаргаас эгц дээш 1.4 м/с хурдтай шидсэн бол биеийн кинетик ба газрын гадаргатай харьцангуй потенциал энэргүүд тэнцэх үеийн хурдыг олно уу?

$\sqrt{2} = 1.4$ гэж тооцно уу. (2 оноо)


- A. 1 м/с B. 2 м/с C. 3 м/с D. 4 м/с E. 5 м/с

26. Саванд байгаа ρ_1 нягттай шингэн дээр түүнтэй үл холилдох ρ_2 ($\rho_1 > \rho_2$) нягттай шингэн нэмэв. ρ ($\rho_1 > \rho > \rho_2$) нягттай, V эзэлхүүнтэй хатуу бие энэ хоёр шингэний зааг дээр байгаа бол нягт ихтэй ρ_1 шингэнд орших биеийн хэсгийн эзэлхүүнийг олно уу. (2 оноо)

- $\rho_2 = 0.6 \frac{\text{г}}{\text{см}^3}$, $\rho_1 = 1 \frac{\text{г}}{\text{см}^3}$, $\rho = 0.9 \frac{\text{г}}{\text{см}^3}$, $V = 1 \text{см}^3$ гэж тооцно уу. (2 оноо)
 A. $V = 0.50 \text{см}^3$ B. $V = 0.75 \text{см}^3$ C. $V = 1 \text{см}^3$ D. $V = 1.50 \text{см}^3$ E. $V = 2.50 \text{см}^3$


27. Гармоник хэлбэлзэл хийж байгаа пүршин дүүжингийн ачааны координат хугацаанаас хамааран зурагт дүрсэлсний дагуу өөрчлөгднө. Хэлбэлзлийн үе болон далайцыг олно уу? (2 оноо)

- A. $T = 2c$, $A = 6 \text{см}$ B. $T = 4c$, $A = 3 \text{см}$ C. $T = 6c$, $A = \sqrt{3} \text{см}$ D. $T = 8c$, $A = 6 \text{см}$ E. $T = 8c$, $A = 3 \text{см}$



28. Зурагт үзүүлсэн хэлхээний R_2 эсэргүүцлээр гүйх гүйдлийн хүчийг олно уу? (2 оноо)

- A. 6 A B. 2 A C. 3 A D. 2/3 A E. 3/2 A




29. Цэгэн гэрэл үүсгэгч S тунгалаг бус бөмбөрцөг биетийн төвөөс $a = 2 \text{м}$ зайд оршино. Дэлгэц биетийн төвөөс $b = 1 \text{м}$ зайд байрлах ба дэлгэцэн дээрх сүүдрийн радиус $r = 2.7 \text{м}$ бол биетийн радиусыг олно уу? (2 оноо)

- A. 5.4 м B. 1.8 м C. 1.35 м D. 4/3 м E. 3/4 м

30. $m = 5 \text{кг}$ масстай бие $v = 6 \text{ м/с}$ хурдтай явж байсан бол биетийн хөдөлгөөний кинетик энергийг олно уу. (2 оноо)

- A. 18 Ж B. 72 Ж C. 45 Ж D. 144 Ж E. 90 Ж



31. Графикт биед үйлчилсэн хүч ба хүчний үйлчлэлээр биетийн явсан замыг харуулжээ. Энэ хүчний хийсэн ажлыг олно уу? (2 оноо)

- A. Fa B. $2Fa$ C. $3Fa$ D. $4Fa$ E. $5Fa$

32. Ахь биед хэвтээ хавтгайн дагуу 10м/с хурд олгоод орхисон бол бие зогстолоо ямар зам туулах вэ? Бие ба гадаргын үрэлтийн коэффициент $\mu = 0.1$, $g = 10 \text{м/с}^2$ Агаарын эсэргүүцэл тооцохгүй. (2 оноо)

- A. 50 м B. 200 м C. 100 м D. 25 м E. 75 м

33. Хэрэв өргөн хөндлөн огтлол бүхий хоолойгоор ус 8 см/с хурдтай урсаж байсан бол түүнээс 3 дахин бага диаметртай хоолойн хэсгээр ямар хурдтай урсах вэ? (2 оноо)

- A. 160 см/с B. 72 см/с C. 150 см/с D. 90 см/с E. 100 см/с

34. Биетийн цахилгаан шинжтэй холбоотой хэллэгүүдээс зөвийг нь сонгоно уу. (2 оноо)

- I. Биесийг шүргэлтээр цахилгаанжуулж болно
- II. Атом нь сөрөг цэнэгтэй протон ба эзэрэг цэнэгтэй нейтроныг өөртөө агуулдаг
- III. Биетийг шүргэлтээр цэнэглэхээс гадна гэрлийн үйлчлэлээр цэнэглэх үзэгдэл байдаг


- A. I ба III B. Зөвхөн II C. Зөвхөн III D. I ба II E. II ба III

35. Фотоэффеktийн үзэгдлийн үед туссан гэрлийн фотоны энерги ($h\nu$) нь электрон гаралтын ажил ба фото электроны кинетик энергид зарцуулагдана гэж үзнэ. Үүнийг энерги хадгалагдах хуулийн үүднээс зөв томъёолж Планкийн тогтмолыг зөв илэрхийлсэн хариуг сонгоно уу? (2 оноо)

- A. $\nu = \frac{A+E_k}{h}$ B. $h = \frac{A+E_k}{\nu}$ C. $A = h\nu - E_k$ D. $E_k = h\nu - A$ E. $E_k = h\nu + A$

36. Зурагт ижил урт, диаметр бүхий хоёр өөр материалыаар хийсэн пүршний суналт үйлчилсэн хүчинээс хэрхэн хамаарсныг үзүүлжээ. Зурагт өгөгдсөнөөр пүрш тус бүрт адил 6 нэгж хүч үйлчлэх үеийн пүршний потенциал энэргүүдийн харьцаа E_1/E_2 -ийг олно уу? (2 оноо)

- A. 1/2 B. 2 C. 1/4 D. 4 E. 1



37. Идеал хийн температурыг изобараар 320К хэмжээгээр бууруулахад түүний эзэлхүүн хоёр дахин багассан бол идеал хийн анхны температурыг олно уу? (2 оноо)


- A. 273 K B. 1425 K C. 320 K D. 640 K E. 580 K

38. Биеийн координат хугацааны хамаарал $x(t) = 3t + 4t^2$ гэж өгөгдөв. Биеийн массыг $t = 3$ кг гэж тооцоод хөдөлгөөн эхэлснээс хойш $t = 4$ с агшин дахь биеийн импульсыг олно уу. (2 оноо)

- A. 96 кг·м/с B. 105 кг·м/с C. 126 кг·м/с D. 12 кг·м/с E. 36 кг·м/с

39. Эерэг q цэнэгтэй бөөм нэгэн төрлийн соронзон оронд зурагт үзүүлсний дагуу хэвтээ хавтгайд R радиустай тойргоор эргэнэ. Босоо хавтгайд зурагдсан чиглэлүүдээс аль нь орны индукцийн векторын чиглэлийг зөв зааж байна вэ? (2 оноо)

- A. 1 B. 2 C. 3 D. 4 E. B=0



40. Нэгэн төрлийн ижил хоёр цул бөмбөрцөг шүргэлцэн хоорондоо F_1 хүчээр таталцана. Бөмбөрцгүүдийн нягт ба шүргэлцсэн байрлалыг өөрчлөхгүйгээр тус бүрийн массыг n дахин ихэсгэвэл гравитацийн таталцлын хүч хэд дахин өөрчлөгддөх вэ? $\frac{F_2}{F_1} = ?$ (2 оноо)

- A. $n^{\frac{3}{4}}$ B. $2n^{\frac{4}{3}}$ C. $n^{\frac{4}{3}}$ D. n^2 E. n

41. Биеийн хөдөлгөөний эхний 125 м замд ажигласан үр дүнг хүснэгтээр өгчээ.

Зам, м	0	10	25	45	65	85	105	125
Хугацаа, с	0	2	4	6	8	10	12	14

Хөдөлгөөний 9 с агшин дахь хурд ба эхний 9 секундэд туулсан замыг олно уу? (2 оноо)

- A. $v = 10 \frac{m}{c}, S = 55m$ B. $v = 10 \frac{m}{c}, S = 75m$ C. $v = 10 \frac{m}{c}, S = 95m$
D. $v = 10 \frac{m}{c}, S = 115m$ E. $v = 10 \frac{m}{c}, S = 65m$

42. Хоёр бие $F_1 = \gamma \frac{Mm}{R^2}$ хүчээр таталцана. Хэрэв тус бүрийн массыг 4 дахин багасгаж мөн хоорондын зайл нь 8 дахин багасгахад харилцан үйлчлэлийн хүч F_2 болсон бол $\frac{F_2}{F_1}$ –харьцааг олно уу. (2 оноо)

- A. 4 B. 8 C. 12 D. 32 E. 6

43. Инерциал тооллын системд байгаа m масстай биед \vec{F} хүч нь \vec{a} хурдатгал олгоно.

Энэ тооллын системд $\frac{1}{4}\vec{F}$ хүчний үйлчлэлээр $3m$ масстай биеийн олж авах хурдатгалыг олно уу? (2 оноо)

A. \vec{a}

B. $\frac{1}{6}\vec{a}$

C. $\frac{1}{12}\vec{a}$

D. $\frac{3}{8}\vec{a}$

E. $6\vec{a}$

44. Зургийн хавтгайд I гүйдэлтэй шулуун урт хэвтээ байрлалтай дамжуулагчийн дагуу чиглэсэн протоны хурд v байсан бол протонд үйлчлэх Лоренцын хүч хаашаа чиглэх вэ? Протоныг зургийн хавтгайд хөдөлнө гэж үзнэ. (2 оноо)


A. Зургийн хавтгай дээр доошоо ↓

B. Зургийн хавтгай дээр зүүн тийш ←

C. Зургийн хавтгайд перпиндикуляр бидэн лүү

D. Зургийн хавтгай дээр дээшээ ↑

E. Зургийн хавтгай дээр баруун тийш →



45. Тус бүр 1 Ом, 2 Ом, 3 Ом, 4 Ом эсэргүүцлүүдийг ерөнхий эсэргүүцэл нь 1 Ом байхаар холбов. Хэрэв 4 Ом эсэргүүцэл дээгүүр 2 А гүйдэл гүйж байсан бол 2 Ом эсэргүүцэл дээр ялгарах чадлыг олно уу. (2 оноо)

A. 32 Вт

B. 72 Вт


C. 16 Вт

D. 25 Вт

E. 50 Вт

46. Зурагт идеал хийн эзэлхүүн температурын хамаарлын VT – диаграммыг дүрслэсэн. Хийн масс тогтмол бол аль цэгийн даралт хамгийн бага вэ? (2 оноо)

A. 1 B. 2 ба 4 C. 3 D. 4 E. 2



Хоёрдугаар хэсэг: Нөхөх даалгавар

Хариултын хуудсаа үзнэ үү. Дараах даалгавруудын ($a, b, c, d \dots$ гэх мэт) үсгүүдэд тохирох (0, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9) цифр ба (-) тэмдэг сонгож үсэгт харгалзуулан бичиж хариултын хуудсанд бөглөнө. Жишээ нь: $[cde] = -15$ гэвэл $c = -, d = 1, e = 5$ гэж харгалзуулна.

2.1. Хэмжих хязгаар нь $I = 1 A$ байх амперметрт $R_{ш} = 1 \Omega$ эсэргүүцэлтэй шунт холбоход түүний хуваарийн үнэ 10 дахин ихсэв.

1. Амперметрийн шинэ хэмжих хязгаар нь $[ab]$ А болсон. (1 оноо)
2. Амперметрийн дотоод эсэргүүцэл $[c]$ Ом байсан. (1 оноо)
3. Шунтыг салгаж энэ амперметрийг ашиглан 11 В хүчдэл хэмжихийн тулд хамгийн багадаа $[d]$ Ом нэмэлт эсэргүүцэл холбоно. (1 оноо)
4. Дээрх нэмэлт эсэргүүцэл дээр $[e]$ В хүчдэл унах ба $[f]$ А гүйдэл гүйнэ. (2 оноо)

2.2. Тайван байсан $m = 10\text{ кг}$ масстай ачааг хэвтээ хавтгайгаар $a = 1.5\text{ м/с}^2$ хурдатгалтайгаар чирэв. $g = 10\text{ м/с}^2$

1. Үрэлтийн коэффициент $\mu = 0.1$ гэвэл үрэлтийн хүчний хэмжээ $[ab]$ Н байна. (1 оноо)
2. Ачааг чирэх хүчний хэмжээ $[cd]$ Н. (1 оноо)
3. Хөдөлгөөний эхний 2 м замд чирэх хүчний хийсэн ажил $[ef]$ Ж. (1 оноо)
4. Хөдөлгөөний эхний 3 м замын эцэст биеийн кинетик энерги $[gh]$ Ж байна. (2 оноо)

2.3. $m = 0.1\text{ кг}$ масстай биеийг газрын гадаргаас 70 м өндөрт орших цэгээс эгц дээш 30 м/с хурдтай шидэв. $g = 10\text{ м/с}^2$, агаарын эсэргүүцэл тооцохгүй.

1. Бие хөөрөлтийн дээд цэгтээ хүрэх хугацаа $[a]$ с байна. (1 оноо)
2. Хөөрөлтийн хамгийн их өндөр газрын гадаргаас $[bcd]$ м байна. (1 оноо)
3. Хөдөлгөөн эхэлснээс хойш $t = 1\text{ с}$ хугацааны дараа биеийн кинетик энерги $[ef]$ Ж байна. (1 оноо)
4. Газрын гадаргатай харьцангуй потенциал энерги нь хөдөлгөөн эхэлснээс хойш $t = 7\text{ с}$ хугацааны дараа $[gh]$ Ж байна. (2 оноо)

2.4. Зурагт өгөгдсөн эгц босоо гөлгөр ханыг $m = 130\text{ г}$ масстай бөмбөг зурагт үзүүлснээр $\alpha = 30^\circ$ өнцгөөр $v = 10\text{ м/с}$ хурдтай ирж мөргөөд мөн хурдтайгаар ойв. Хүндийн хүчний нөлөөг тооцохгүй.

1. Мөргөлтийн өмнө бөмбөгний импульсийн хэвтээ байгуулагч $[a, bc] \text{ кг} \cdot \text{м/с}$ (1 оноо)
2. Мөргөлтийн дараа импульсийн хэвтээ байгуулагчийн өөрчлөлт $[d, e] \text{ кг} \cdot \text{м/с}$ (1 оноо)
3. Мөргөлтийн дараах импульсийн босоо байгуулагчийн өөрчлөлт $[f]$ байна. (1 оноо)
4. Мөргөлт $\Delta t = 0.1\text{ с}$ үргэлжилсэн гэвэл хананы зүгээс бөмбөгөнд үйлчилсэн дундаж хүч $[gh]$ Н байна. (2 оноо)

